



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны ix сарын 09 өдөр

Дугаар A/292

Мөрөн сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх яаралтай дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх, хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг Рашаант сумын хорио цээр тогтоосон бүс нутгийн голомт, сэжигтэй бүсэд нутаглаж байгаа малчин өрхийн бог малыг бүрэн хамруулан 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг Рашаант сумын Засаг даргад даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, ариутгалын бодис, хамгаалах хувцас хэрэгсэлийг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Нямдорж), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН